



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2015 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3 дахь заалт, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор дараах арга хэмжээг 2015 оны 07 дугаар сарын 01-ний дотор хэрэгжүүлж, ажлын үр дүнг 08 дугаар сарын 01-ний дотор танилцуулахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ц.Уртнасан)-т даалгасугай.

1. Нэрийн дансны 2015 оны орлогод тооцох жилийн хүүг тооцож, Үндэсний Статистикийн хорооноос санал авч, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлэх;

2. Баталсан хүүгийн хэмжээг үндэслэн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны улирал бүрийн орлогод хүү тооцох ажлыг дараа улирлын эхний сард багтаан хэрэгжүүлж ажиллах;

3. Нэрийн данснээлгэсэн даатгуулагчаас нас барсан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, харьяатаас гарсан иргэдийн мэдээллийг тулган шалгаж, тусад нь тэмдэглэх;

4. Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн дагуу ажилласан жил тооцуулсан 1960 оноос хойш төрсөн даатгуулагчийн нөхөн тооцуулсан хугацааг холбогдох хууль, журмын дагуу нэрийн дансны орлогод оруулан тооцох;

Хоёр. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (М.Саранчимэг)-нд даалгасугай.

ДАРГА  С.ЭРДЭНЭ

